



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 11 сарын 20 өдөр


Дугаар 331

Улаанбаатар хот

Багцын арилжааг төлбөр тооцооны Т+3 хугацааны горимд хийх тухай

Үнэт цаасны зах зээлийн арилжаа, төлбөр тооцооны горимын шинэчлэл хийгдэж байгааг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалт, Монголын хөрөнгийн бирж” ХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хяналтын “Миллениум Ай Ти” системийг 2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн нэвтрүүлсэнтэй холбогдуулж Хөрөнгийн бирж дээр хийгдэх багцын арилжааг 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн төлбөр тооцооны Т+3 хугацааны горимоор хийхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д зөвшөөрсүгэй.
2. Энэ тогтоолын 1-т заасан багцын арилжааны томъёолол, түүний төлбөр тооцоог хэрхэн хийх талаарх зөвлөмжийг баталж, мөрдүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

001820